

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/12/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: А.Нарандэлгэр

Утас: 70432545

цахим хаяг: narandelgera@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт: .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

МӨСТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ ЭМЧ  
З.БОЛОРМАА ТАНАА

2022.03.31 № 2/20

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөст сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Мөст сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд эмийн тайланг бэлтгэхдээ орлогын баримт үйлдээгүй, няргын тайлан санхүүгийн программаар бэлтгэсэн тайлантай таарахгүй байгаа, Эмийн тайланг шалгаж хүлээн аваагүй, тооцоо бодоогүй, өмнөх оны аудитын зөвлөмжийг биелүүлээгүй, шатахууны зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, нягтлан бодогч, нярваар гарын үсэг зуруулаагүй, дуудлагын журналын бүртгэл дутуу, бусад жолоочид олгосон шатахуун нь анхан шатны баримтаар нотлогдохгүй, Эмийн тайлангийн үлдэгдэл зөрүүтэй, бүртгэлээрх үлдэгдэл тооллогын үлдэгдэлтэй таарахгүй байгаа, эмийн захиасыг бүрэн бүрдүүлж зарлагадаагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, Эрхлэгч эмч Пүрэвбаатар, Болормаа нарт батлагдаагүй орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл олгосон, Эрхлэгчээр ажиллаж байсан Пүрэвбаатарт хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгосон, шалгуур үзүүлэлтгүй үр чадварын нэмэгдлийн ажилсан жилд харгалзуулан олгосон, ЭМДС-аас авах гүйцэтгэлийн санхүүжилтийг дутуу авч, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, ковидын тест оношлуурын захиалгыг оновчгүй өгч төсөвт үр ашиггүй худалдан авалт хийж, оношлуурын үлдэгдэлтэй, төлбөр тооцоог хийгээгүй өртэй байгаа зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

• 021020401

хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам", Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Үнэн зөв байх", "Иж бүрэн байх", "Тохиолдсон байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>92,316,952.24</u></b>	<b><u>171,827,528.10</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	645,625.34
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	645,625.34
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	645,625.34
31211	Төрийн сангийн харилцах	00.00	645,625.34
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	6,339,000.00	23,956,435.87
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	606,600.00	764,980.87
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	22,212,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,732,400.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	979,455.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	979,455.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	85,977,952.24	147,225,466.89
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	42,367,129.04	97,987,515.46
35130	Эм боох материал	42,367,129.04	97,987,515.46
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	43,610,823.20	49,237,951.43
35410	Бичиг хэргийн материал	28,000.00	560,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,688,000.00	1,940,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,350,000.00	3,980,000.00
35460	Хүнсний материал	300,000.20	1,100,800.20
35470	Бусад хангамжийн материал	38,244,823.00	41,656,651.23
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>580,798,655.93</u></b>	<b><u>585,403,374.54</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	580,798,655.93	585,403,374.54
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	570,318,656.09	575,099,374.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	490,354,000.00	513,354,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-26,325,720.20	-42,138,700.41
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,052,000.00	113,752,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-71,423,444.70	-83,278,500.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	135,670,257.10	149,608,331.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	-105,385,564.30	-86,808,475.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,513,406.00	43,513,406.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,136,277.81	-32,902,687.69
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	10,479,999.84	10,304,000.00
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-704,000.16	-880,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,304,000.00	10,304,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>673,115,608.17</u></b>	<b><u>757,230,902.64</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>14,463,424.29</u></b>	<b><u>73,281,642.56</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	14,463,424.29	73,281,642.56
<b>413</b>	<b>Өглөг</b>	14,463,424.29	73,281,642.56
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,874,072.38	2,997,896.65
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	8,279,157.14	66,659,401.14

<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,310,194.77	3,624,344.77
41361	Байгууллагад төлөх өглөг	1,240,852.00	1,407,652.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	69,342.77	2,216,692.77
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>658,652,183.88</b>	<b>683,949,260.08</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	658,652,183.88	683,949,260.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	176,837,308.00	176,837,308.00
51101	Өмч: - төрийн	176,837,308.00	176,837,308.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	66,866,500.80	92,163,577.00
51210	Өмнөх үеийн үр дүн	66,866,500.80	66,866,500.80
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	25,297,076.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	414,948,375.08	414,948,375.08
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>673,115,608.17</b>	<b>757,230,902.64</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>601,722,400.00</b>	<b>723,531,622.96</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>37,900,000.00</b>	<b>513,247,960.96</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	19,859,660.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	19,859,660.96
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	19,859,660.96
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	37,900,000.00	33,332,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	37,900,000.00	33,332,000.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	00.00	460,056,300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	460,056,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>563,822,400.00</b>	<b>210,283,662.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	459,497,900.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	459,497,900.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,942,400.00	36,672,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,942,400.00	36,672,880.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	16,906,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	16,906,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	00.00	23,000,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	00.00	23,000,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	94,382,100.00	133,704,782.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	94,382,100.00	133,704,782.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>556,341,680.72</b>	<b>698,234,546.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>556,341,680.72</b>	<b>698,234,546.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	555,821,680.72	663,034,546.76
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	370,879,867.15	398,825,371.29
210101	Үндсэн цалин	370,879,867.15	398,825,371.29
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,435,131.00	52,180,085.77

210201	Тэтгэврийн даатгал	31,498,183.00	36,037,614.60
210202	Тэтгэмжийн даатгал	3,736,750.00	4,059,369.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,989,380.00	3,222,158.99
210204	Ажилгүйдлийн даатгал	737,348.00	805,539.09
210205	Эрүүл мэндийн даатгал	7,473,470.00	8,055,403.22
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,301,145.00</b>	<b>16,645,722.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,301,145.00	2,795,972.00
210302	Түлш, халаалт	7,000,000.00	13,849,750.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>32,811,850.00</b>	<b>30,917,840.00</b>
210401	Бичиг хэрэг	4,332,050.00	4,486,400.00
210402	Тээвэр, шатахуун	25,311,800.00	24,088,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,504,000.00	2,253,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	664,000.00	90,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>71,480,323.31</b>	<b>90,485,744.58</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,725,273.31	77,501,294.58
210502	Хоол, хүнс	17,755,050.00	12,984,450.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,063,000.00</b>	<b>2,839,800.00</b>
210604	Урсгал засвар	4,063,000.00	2,839,800.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>559,500.00</b>	<b>984,000.00</b>
210702	Дотоод албан томилот	559,500.00	984,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>656,168.00</b>	<b>756,978.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,160.00	109,160.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	108,900.00	97,210.00
210807	Газрын төлбөр	20,608.00	20,608.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	24,500.00	10,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,634,696.26</b>	<b>69,399,005.12</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	944,500.00	7,107,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,690,196.26	62,291,605.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>520,000.00</b>	<b>35,200,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>520,000.00</b>	<b>35,200,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	520,000.00	35,200,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>45,380,719.28</u></b>	<b><u>25,297,076.20</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>45,380,719.28</u></b>	<b><u>25,297,076.20</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308.00	420,699,095.08	50,037,597.31	647,574,000.39
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	176,837,308.00	420,699,095.08	50,037,597.31	647,574,000.39

C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-34,302,535.79	-34,302,535.79
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>176,837,308.00</b>	<b>414,948,375.08</b>	<b>66,866,500.80</b>	658,652,183.88
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>176,837,308.00</b>	<b>414,948,375.08</b>	<b>66,866,500.80</b>	658,652,183.88
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>176,837,308.00</b>	<b>414,948,375.08</b>	<b>66,866,500.80</b>	658,652,183.88
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	25,297,076.20	25,297,076.20
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>176,837,308.00</b>	<b>414,948,375.08</b>	<b>92,163,577.00</b>	683,949,260.08

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>563,822,400.00</b>	<b>625,127,962.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>460,056,300.00</b>
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	00.00	460,056,300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	460,056,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>563,822,400.00</b>	<b>165,071,662.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	459,497,900.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	459,497,900.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,942,400.00	36,672,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,942,400.00	36,672,880.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	16,906,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	16,906,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	94,382,100.00	111,492,782.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	94,382,100.00	111,492,782.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>563,822,400.00</b>	<b>624,482,336.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>563,822,400.00</b>	<b>624,482,336.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>563,822,400.00</b>	<b>589,282,336.66</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	373,166,500.00	399,714,095.66
210101	Үндсэн цалин	207,694,700.00	223,102,600.00
210102	Нэмэгдэл	128,311,600.00	118,142,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,006,000.00	7,308,000.00
210104	Урамшуулал	31,154,200.00	51,161,095.66
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,765,700.00	53,865,146.00
210201	Тэтгэврийн даатгал	32,909,200.00	37,821,631.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,464,100.00	4,010,903.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,771,300.00	3,208,723.00
210204	Ажилгүйдлийн даатгал	692,800.00	802,181.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,928,300.00	8,021,708.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,126,645.00	14,656,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,196,000.00	2,196,000.00

210302	Түлш, халаалт	8,825,500.00	12,325,000.00
210303	Цэвэр, бохир ус	105,145.00	135,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,003,150.00</b>	<b>31,218,855.00</b>
210401	Бичиг хэрэг	845,750.00	1,583,500.00
210402	Тээвэр, шатахуун	22,933,100.00	24,838,855.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,504,000.00	2,796,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,720,300.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>80,336,437.00</b>	<b>79,719,240.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,837,652.00	67,719,240.00
210502	Хоол, хүнс	15,977,115.00	10,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	521,670.00	2,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,455,900.00</b>	<b>3,250,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,627,900.00	1,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	333,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,495,000.00	2,250,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>559,500.00</b>	<b>984,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	559,500.00	984,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,156,168.00</b>	<b>875,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,160.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	108,900.00	120,000.00
210807	Газрын төлбөр	20,608.00	55,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	24,500.00	60,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,732,400.00</b>	<b>5,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,732,400.00	5,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>520,000.00</b>	<b>35,200,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>520,000.00</b>	<b>35,200,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	520,000.00	35,200,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>645,625.34</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>645,625.34</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>645,625.34</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	513,821,400.00	513,191,456.66
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	513,821,400.00	513,191,456.66
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	513,821,400.00	513,191,456.66
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	372,945,300.00	372,923,356.66
210101	Үндсэн цалин	223,102,600.00	223,102,600.00
210102	Нэмэгдэл	118,142,400.00	118,142,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,308,000.00	7,308,000.00
210104	Урамшуулал	24,392,300.00	24,370,356.66
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,347,600.00	50,347,600.00
210201	Тэтгэврийн даатгал	35,429,700.00	35,429,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,729,500.00	3,729,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,983,600.00	2,983,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	745,900.00	745,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,458,900.00	7,458,900.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,656,000.00	14,656,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,196,000.00	2,196,000.00
210302	Түлш, халаалт	12,325,000.00	12,325,000.00
210303	Цэвэр, бохир ус	135,000.00	135,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,975,000.00	27,975,000.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,083,500.00
210402	Тээвэр, шатахуун	22,095,000.00	22,095,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,880,000.00	2,796,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	37,372,500.00	37,372,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,372,500.00	25,372,500.00
210502	Хоол, хүнс	10,000,000.00	10,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,250,000.00	3,250,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	2,250,000.00	2,250,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,200,000.00	592,000.00
210702	Дотоод албан томилолт	1,200,000.00	1,200,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	875,000.00	875,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	120,000.00
210807	Газрын төлбөр	55,000.00	55,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000.00	60,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5000000.00	5000000.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	200000.00	200000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	200,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	513,821,400.00	513,837,082.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	460,056,300.00	460,056,300.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	16,906,000.00	16,906,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	16,906,000.00	16,906,000.00
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	36,859,100.00	36,874,782.00
122001	Хандив тусламж /дотоод/	36,859,100.00	36,874,782.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	645,625.34
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	29.00	29.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	498.00	498.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	21.00	21.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	08.00	08.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,942,400.00</b>	<b>111,290,880.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,942,400.00</b>	<b>111,290,880.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	9,942,400.00	111,290,880.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		26,790,739.00
210104	Урамшуулал		26,790,739.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		3,517,546.00
210201	Тэтгэврийн даатгал		2,391,931.00
210202	Тэтгэмжийн даатгал		281,403.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		225,123.00
210204	Ажилгүйдлийн даатгал		56,281.00
210205	Эрүүл мэндийн даатгал		562,808.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		3,243,855.00
210401	Бичиг хэрэг		500,000.00
210402	Тээвэр, шатахуун		2,743,855.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	914,000.00	42,346,740.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	914,000.00	42,346,740.00

2107	<b>Томилолт, зочны зардал</b>		392,000.00
210702	Дотоод албан томилолт		392,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9,028,400.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,028,400.00	-
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	35,000,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		35,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		35,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	9,942,400.00	111,290,880.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	429,400.00	74,618,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,217,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,296,000.00	36,672,880.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд и баримт, цалингийн зардал, гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор А.Нарандэлгэр 2022 оны 03 дугаар сарын 22-ноос 2021 оны 03 дугаар сарын 31-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн албан тооттой боловч иж бүрдэл болсон санхүүгийн тайлан, анхан шатны баримтыг 2022.03.22-ны өдөр ирүүлж Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацааг баримтлаагүй байна.

Тус аудитыг гүйцэтгэхэд өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, их хэмжээний эмийн үлдэгдэл байгаа эсэх нь тодорхой бус, анхан шатны баримтууд хангалтгүй, ажил хариуцсан албан тушаалтнуудын ажлын хариуцлага сул зэргээс аудитад шаардлагатай нотлох баримтуудаар хангагдаж чадаагүй болно.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Мөст сумын эрүүл мэндийн төв нь “Үйлчлэх хүрээний хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд чанартай,

хүртээмжтэй үзүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтууд дэвшүүлэн ажилласан байна.

Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулан, хүн амын эрүүлжүүлэх үйлсэд уламжлалт анагаах ухааныг өргөн ашиглах, ард иргэдэд эрүүл мэндийнхээ төлөө зөв дадал, зан үйлийг хэвшүүлэх явдал тухайн байгууллагын үйл ажиллагааны гол чиг үүрэг болон ажиллажээ.

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах.
- Хүний нөөцийн мэдлэг ур чадварыг тасралтгүй нэмэгдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад 2021 онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны нийт зарлагын 698.2 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 10.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84.1 сая төгрөгөөр буюу 12.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өглөг, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд төрийн сангийн харилцах дансанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байсан ба эцэст 0.6 сая төгрөг байна

Бараа материалын дансны үлдэгдэл 147.2 сая төгрөг болж 61.2 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал 55.6 сая төгрөг, хангамжийн материал 5.6 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 183.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 12.9 сая төгрөгөөр нийт 196.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 135.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Авлагын данс оны эцэст 23.9 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны цэвэр үлдэгдэл оны эхэнд 580.7 сая төгрөг байсан бол оны эцэст 585.4 сая төгрөг болж 4.7 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 812.7 сая төгрөг байсан бол оны эцэст 831.4 сая төгрөг болж 18.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 3.7 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 63.2 сая төгрөгийн хөрөнгө орлого авч, 48.2 сая төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Тайлант оны эцэст 73.3 сая төгрөгийн өр үүссэн байгаа нь тээвэр шатахууны зардлын 4.4 сая төгрөг, ажиллагсадтай холбоотой 2.9 сая төгрөг, эмийн зардалд 59.5 сая, гэрэл цахилгааны зардалд 0.4 сая төгрөг, хоолны зардалд 1.8 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 658.6 сая төгрөг байсан оны эцэст 683.9 сая төгрөг болж тайлант онд өөрчлөлт гарсан нь тайлант оны үр дүн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бичилт хийгдээгүй тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 92.2 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Эрүүл мэндийн төв нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвийн санхүүжилтээр 525.4 сая төгрөг, ЭМД-аас 65.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 591.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

ЭМГ-аас тус байгууллагын төсвийг төсвөөс 460.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 16.9 сая төгрөг, ЭМД-аас 36.8 сая төгрөг нийт 513.8 сая төгрөг батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсвөөс 460.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 16.9 сая төгрөг, ЭМД-аас 14.8 сая төгрөг, ковидын санхүүжилтээс 22.0 сая төгрөг нийт 513.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, ЭМД-аас санхүүжих санхүүжилтийг 22.0 сая төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 513.1 сая төгрөг буюу 99.8 хувь зарцуулж төсвийн хэмнэлт гаргаагүй тайлант оны үйл ажиллагааны зардлыг батлагдсан төсвийн хэмжээнд бүрэн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ЭМГ-аас 1.6 сая төгрөгийн санхүүжилт, ковид-2019 цар тахлын үеэр ажилласан илүү цаг, томилолт, вакцины урамшуулал болох 96.6 сая төгрөг, ЭМЯ-аас сайдын тушаалаар эрүүл мэндийн ажилчдын нэг удаагийн буцалтгүй тусламж 35.0 сая төгрөг, нийт 111.3 сая төгрөгийн санхүүжилт авч, 111.3 сая төгрөгийг холбогдох арга хэмжээнд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайланг гүйцэтгэх хугацаанд 1 өргөдөл ирсэн тул өргөдлийн дагуу мэдээллийг нягтлан шалгахад ргэд олон нийтэд толилуулах дараах асуудлууд байна. Үүнд.

1. ЭМДС-аас авах санхүүжилтийг бүрэн авч цалингийн зардлыг бүрэн санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн ба 2021 оны 3-10 хүртэлх хугацаанд даатгалаас санхүүжилт авч чадаагүйн улмаас нийгмийн даатгалын шимтгэл, татварын өр төлбөр сар бүр нэмэгдэж оны эцэст 22.0 сая төгрөгийн НДШ-ийн өрийг төлсөн байна. Байгууллагын батлагдсан цалингийн сангийн төсвийг зохистой удирдаагүй, гүйцэтгэлээр авах ЭМД санхүүжилтийг сар бүр тайлагнаж аваагүй байхад нийт албан хаагчдад сар бүр ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон, эрхлэгч эмч батлагдаагүй орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл, хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийг авсан зэрэг нь цалин хөлстэй холбоотой өр үүсэх нөхцөл болсон байна.
2. Байгууллагын шатахууны зарцуулалтыг түүвэрлэн хянахад нягтлан, нярваар шатахууны зарцуулалтад хяналт хэрэгжүүлдэггүй, байгууллагын 1 дүгээр гарын үсэг шатахууны бичиг олгож ирсэн байна. Аудитаар 2021 оны 1 дүгээр сарын шатахуунд зарцуулсан 1.2 сая төгрөгөөс 0.4 сая төгрөг нь дуудлагын журналын тохирч, үлдэх зарцуулалт анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Ковид-19 цар тахлын үед тус Эрүүл мэндийн төв нь 107 хүнийг тусгаарлах байранд хэвтүүлэн эмчилж, гэрийн тусгаарлалтад 216 хүнд эмийн багц өгч, 1867 хүнд оношилгоо шинжилгээ хийж, 28790 ширхэг 63.7 сая төгрөгийн нэг удаагийн хэрэгслийг худалдан авсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

#### **3. 3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал нь бэлтгэсэн тайлангийн тоо мэдээлэл нь уялдаа холбоогүй, зөрүүтэй илэрхийлэгдсэн, эмийн захиасыг үндэслэлгүй тооцоо судалгаагүй өгснөөр 2700 ширхэг буюу 32.4 сая төгрөгийн ковидын тестийн үлдэгдэлтэй байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 22.2 сая төгрөгийн авлага, байгууллагад төлөх 73.3 сая төгрөгийн өр үүссэн, өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг 87.5 хувьтай мэдээлсэн байна. Ховд аймгийн Мөст сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 гүйлгээг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:** Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.3 сая төгрөгийн алдаа зөрчлийн 1 төлбөрийн акт бичигдсэний 0.9 сая төгрөг нь хэрэгжсэн, хэрэгжилт дутуу, 25.1 сая төгрөгийн 1 албан шаардлага, 16.8 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байгууллагад төлөх өр төлбөрийн барагдуулалт, бараа материалын тайланг үнэн зөв гаргаж, тооцоо бодсон эсэх, шатахууны зардал, эмийн зардалд удирдлагын зүгээс тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж авч үзэх шаардлагатай байна..

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 285.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 15.6 сая төгрөгийн 2 залруулга, 169.4 сая төгрөгийн 4 албан шаардлага, 76.0 сая төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

#### 1.1 Санхүүгийн тайлагналтай холбоотой

1. ЭМГ-аас шилжүүлсэн ковидын үйл ажиллагаанд ариутгалын бодис, эм, эмнэлгийн хэрэгсэл зэрэг бараа материалыг орлогод аваагүй 11.9 сая төгрөг,
2. Худалдаж авсан үндсэн хөрөнгийг буруу бүртгэсэн 3.7 сая төгрөг нийт 15.6 сая төгрөг,

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 15.6 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 03 дугаар сарын 30-ны 12 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

### 4.2 Төлбөрийн акт

*Аудитад ирүүлсэн нотлох баримтуудаар эм, шатахуун, цалингийн зардалтай холбоотой асуудлыг дахин хянах шаардлагатай тул төлбөрийн акт тогтоогоогүй болно.*

### 4.3 Албан шаардлага

- Эмийн тайланг бэлтгэхдээ орлогын баримт үйлдээгүй, нярвын тайлан санхүүгийн программаар бэлтгэсэн тайлантай таарахгүй байгаа, Эмийн тайланг шалгаж хүлээн аваагүй, тооцоо бодоогүй, өмнөх оны аудитын зөвлөмжийг биелүүлээгүй 121.2 зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
- Шатахууны зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, нягтлан бодогч, нярваар гарын үсэг зуруулаагүй, дуудлагын журналын бүртгэл дутуу, бусад жолоочид олгосон шатахуун нь анхан шатны баримтаар нотлогдохгүй 24.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
- Эмийн тайлангийн үлдэгдэл зөрүүтэй, бүртгэлээрх үлдэгдэл тооллогын үлдэгдэлтэй таарахгүй байгаа, эмийн захиасыг бүрэн бүрдүүлж зарлагадаагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй 48.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
- Эд хариуцагчийн тайланг хугацаанд гаргаагүй, анхан шатны баримтыг дутуу хөтөлж, бараа материалын тайланг зөрүүтэй тайлагнасан нярав Ц.Золзаяад ажлын хариуцлага тооцуулах.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулж зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт1: Эрхлэгч эмч Пүрэвбаатар, Болормаа нарт батлагдаагүй орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл олгосон, Эрхлэгчээр ажиллаж байсан Пүрэвбаатарт хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгосон, шалгуур үзүүлэлтгүй ур чадварын нэмэгдлийн ажилсан жилд харгалзуулан олгосон 21.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3-д ""Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо ажиллагчдын цалин хөлсийг тогтоох"" гэсэн заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4-д ""Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно" гэсэн заалтуудыг баримталж ажиллах.

**Илрүүлэлт 2:** ЭМДС-аас авах гүйцэтгэлийн санхүүжилтийг дутуу авч, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, үндсэн үйл ажиллагаа нь доголдсон 21.9 сая төгрөг, ковидын тест оношлуурын захиалгыг оновчгүй өгч төсөвт үр ашиггүй худалдан авалт хийж 30.2 сая төгрөгийн оношлуурын үлдэгдэлтэй, төлбөр тооцоог хийгээгүй өртэй байгаа нийт 52.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” гэсэн заалт мөрдөн ажиллах.

**Илрүүлэлт 3:** Бэлтгэн нийлүүлэгчээс бараа материал худалдан авахдаа төлбөрийн баримтаар бүрэн гүйцэд баталгаажуулаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалыг мөрдөн ажиллаж төлбөрийн баримтаар бүрэн гүйцэд баталгаажуулан ажиллах .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөст сумын Эрүүл мэндийн төв	8	285.1	2	15.6	-	-	3	193.5	3	76.0

**Ховд аймаг дахь Төрийн аудитын газар**